


2021
ЭХНИЙ 3 УЛИРАЛЫН ҮЙЛ
АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН



ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

“МОНГОЛ БАЗАЛТ” ХК

КОМПАНИЙН ОНООСОН НЭР : “ МОНГОЛ БАЗАЛТ ” ХУВЬЦААТ КОМПАНИ

БАЙГУУЛСАН ОГНОО : 2007

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛ : ЧУЛУУН ХӨВӨНГИЙН ҮЙЛДВЭР

КОМПАНИЙН АЛБАН ЁСНЫ ХАЯГ : МОНГОЛ УЛС, УЛААНБААТАР ХОТ, СУХБААТАР

ДҮҮРЭГ, 1-Р ХОРОО, ФЛАМИНГО ТАУЭР,

403 ТООТ

УТАС : (976) 7511-4444

ВЭБ : WWW.BASALTWOOL.MN

E-MAIL : MONBASALT@ROCKWOOL.MN


ФЭЙСБҮҮК : MONGOL BASALT JCS

УДИРДЛАГА

ТУЗ - ИЙН ДАРГА : Л.АРИУНБОЛД

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ : А.ЭНХГЭРЭЛ

АЖИЛЧДЫН ТОО : 85



ХУВЬЦААНЫ МЭДЭЭЛЭЛ

ХУВЬЦААНЫ СИМБОЛ КОД : MSE:MBW / 544

МХ БИРЖИД БҮРТГЭГДСЭН : 2018.04.05

НИЙТ ГАРГАСАН ХУГАЦАА : 56,417,000 ШИРХЭГ

ХУВЬЦААНЫ ХАНШ : 209.1 ТӨГРӨГ / 2021.09.30 /

ҮЙЛДВЭРЛЭЛ

ҮЙЛДВЭРИЙН ХҮЧИН ЧАДАЛ : ЦАГТ 1.5 ТОНН






*ИННОВАЦИ ШИНГЭСЭН ҮЙЛДВЭРЛЭЛ ТЕХНОЛОГИОРОО САЛБАРАА
МАНЛАЙЛАН ХӨГЖҮҮЛЖ, ХҮНИЙ АМЬДРАХ ОРЧИНГ ЭРҮҮЛ ТАВ
ТУХТАЙ, БАЙГАЛЬ ДЭЛХИЙД ЭЭЛТЭЙ, БАРИЛГА ХИЙЦИЙН ЭРСДЭЛГҮЙ
ИРЭЭДҮЙ ХОЙЧДОО ӨВЛҮҮЛЭН ҮЛДЭЭХ, ЯМАГТ ӨСӨХ ҮНЭ ЦЭНЭ
БАТАЛГААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫГ БИЙ БОЛГОХ.*

ЭРХЭМ ЗОРИЛГО






БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ



ХҮНИЙ НӨӨЛ:

Монгол Базальт ХК 2021 оны эхний 3 улиралд 85 хүнийг 69 ажлын байранд үндсэн ажилтаны тогтвортой ажлын байраар хангаж нийт 430,6 сая төгрөгөөр цалинжуулсан бөгөөд нэг хүнд дунджаар 1.04 сая төгрөгийн цалин олгосон байна.

Ажилтануудын хүйсийн харьцаа



АЖИЛЧДЫН ТОО	85	АЛБА ХЭЛТЭС	Захигаа-24
АЖИЛЧДЫН ТОО		Үйлдвэр-53	Борлуулалт маркетинг-8
ХҮЙСИЙН ХАРЬЦАА		НАСНЫ БҮТЭЦ	
ЭРЭГТЭЙ	72.5%	50-аас дээш	27%
ЭМЭГТЭЙ	27.5%	40-50 нас	11%
		30-40 нас	26%
		20-30 нас	36%



2020 оноос үргэлжилсэн Ковид-19 цар тахлын үр дагавар 2021 оны эхний улиралд дотоодын эдийн засаг, тэр дундаа барилга бүтээн байгуулалтын салбарын үйл ажиллагаанд хүндрэл бэрхшээлүүд бий болгосон ч 2021 оны эхний хагас жилд үйл ажиллагаанууд бага багаар сэргэж эхэлсэн билээ. Монгол Базальт компанийн хувьд энэ хугацаанд ажилчиддаа тогтвортой ажлын байраар хангах, орлогын эх үүсвэр хангамжийг бууруулахгүй байх бодлогыг нэн тэргүүнд барьж ажилласан юм. Компанийн ашигт ажиллагаанд шууд нөлөөлөх сөрөг хүчин зүйлүүдэд тээвэр логистикийн хомсдол, дотоод болон гадаадын бараа материалын үнийн өсөлт, ААН-үүдийн төлбөрийн чадварын бууралт, томоохон төслүүдийн царцалт, валютын ханшийн өсөлт зэрэг асуудлуудтай олон сар нүүр тулсан хэдий ч бид онцгой цаг үеийн бодлого баримталж баримталж үйл ажиллагааны зардлаа өмнөх оны мөн үетэй харьцуулахад 6%-иар бууруулан, борлуулалтын орлогоо 48.6%-иар, цэвэр ашигаа 3 дахин тус тус өсгөж чадсан бол 3-р улиралын байдлаар борлуулалтын орлогоо 5,8 тэрбумд хүргэж чадсан байна.

2021 оны эхний хагас жилийн

байдлаар бид нийт 2020 оны үйлдвэрлэлтэй тэнцэх хэмжээний бүтээгдэхүүний үйлдвэрлэл явуулсан бөгөөд үүний 70 гаруй хувийг 2-дугаар улиралд үйлдвэрлэсэн юм. 2021 оны 3-р улиралын байдлаар бид бизнес төлөвлөгөөнд заасан хэмжээнд үйлдвэрлэлээ явуулж чадсан бөгөөд 9 сарын 30-ны байдлаар 1053 тн бүтээгдэхүүн үйлдвэрлэж чадсан байна. Энэхүү үйлдвэрлэлийн өсөлт нь эхний улиралд хийгдсэн томоохон капитал хөрөнгө оруулалт болох хөвөн шарах камерны технологийн шинэчилэл засварын ажлын үр дүнг харуулж байна. Дээрх үйлдвэрлэлийн тоо хэмжээний өсөлт 4 дугаар улиралын үр дүнд тусгагдахаар хүлээлттэй байгаа бөгөөд бид жилийн эцэс гэхэд хамгийн багадаа 2500т бүтээгдэхүүн үйлдвэрлэх зорилготой ажиллаж байна.

Үүний хажуугаар бидний эхлүүлсэн 2 томоохон төсөлийн үйлдвэрлэлийн шугам угсралтын шатандаа явагдаж байгаа бөгөөд үйлдвэрлэлийн шугамыг бүрэн ашиглалтанд оруулахаар ажиллаж байна. Энэ цаг үеийн нөхцөл байдалд зөв зохицол төлөвлөлт хийж цаашид компанийн үйл ажиллагааг тогтвортой байлгаж бизнес төлөвлөгөөний дагуу үйлдвэрлэл явуулахыг бид нэн тэргүүний зорилго тавин ажиллаж байна. Үндэсний цор ганц үйлдвэрлэгчийн хувьд бүтээгдэхүүний тоо хэмжээ, төрлүүд нэмэгдэж үүнийг дагаад санхүүгийн үр дүн үзүүлэлтүүд улам бүр сайжирч хэрэглэгч нар, зах зээл болон олон нийт, хувьцаа эзэмшигч нарын хүлээлтийг давуулан биелүүлэх боломж бүрдэнэ гэдэгт итгэлтэй байна.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
А.ЭНХГЭРЭЛ

ЕРДИЙН ГИШҮҮД

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ



ЛХАГВАЖАВ АРИУНБОЛД
ТУЗ-ийн дарга



БАДАРЧ ШАРАВСАМБУУ
ТУЗ-ийн ердийн гишүүн



ПҮРЭВБАНЗРАГЧ САЙНБИЛЭГ
ТУЗ-ийн ердийн гишүүн



ГАЛБАДРАХ ГАНЗОРИГ
ТУЗ-ийн ердийн гишүүн



НАН КҮУ ВОНГ /ХАН ГЮ БУНГ/
ТУЗ-ийн ердийн гишүүн



АРИУНБОЛД ЭНХГЭРЭЛ
Гүйцэтгэх Захирал



ШАРАВСАМБУУ ЭНХТӨР
ТУЗ-ийн хараат бус гишүүн



Пүрэвсүх Нямдорж
ТУЗ-ийн хараат бус гишүүн




ЧАНСАА ЗОРИГТБААТАР
ТУЗ-ийн хараат бус гишүүн

ХАРААТ БУС ГИШҮҮД

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ

БОРЛУУЛАЛТ:



Тайлант он	III улирлын борлуулалтын орлого
2018	1,613,191.0
2019	2,316,016.4
2020	2,321,323.1
2021	5,855,563.3

Тайлант хугацааны борлуулалтын орлогыг өмнөх онуудын мөн үетэй харьцуулахад 2018 оноос 3.7 дахин, 2019 болон 2020 оноос 2.5 дахин их борлуулалт хийсэн. Энэ нь Монгол Базальт ХК-ийн чулуун хөвөн хавтангийн эрэлт хэрэгцээ зах зээлд нэмэгдсээр байгааг харуулж байна.

ХУВЬЦААНЫ МЭДЭЭЛЭЛ:

Хувьцааны ханш



Тайлант хугацаанд хоёрдогч зах зээлд арилжаалагдсан нийт хувьцааны дээд ханш нь 249.53₮, доод ханш нь 160.11₮ байсан бол 2021 оны 3-р улирлын хаалтын ханш 209.1₮ болсон нь тайлант хугацааны өмнөх ханшаас дарай 28.76 ₮ буюу 15.94% өссөн байна.


МОНГОЛБАЗАЛТ (MSE: MBW/544)



МАРКЕТИНГ, СОШИАЛ МЕДИА, КНХ


СОШИАЛ МЕДИАГИЙН ТРЭНД

2021 ОНЫ 1 САР
2021 ОНЫ 9 САР



СОШИАЛ ДАГАГЧДЫН ӨСӨЛТ

2021 ОНЫ 1 САР
2021 ОНЫ 9 САР



МОНГОЛ БАЗАЛТ ХК"-ны 30-н жилийн ойн хүрээнд Олон улсын хүүхдийн эрхийн одрийг тохиолдуулан "ДУЛААХАН БАЙШИН НОГООН ХОТ" Сэдэвтэй хүүхдийн Гар зургийн уралдааныг зарласан.



2021 оны эхний 3 улиралын тайлан


КНХ-ЫН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН АЖИЛ

МОНГОЛ БАЗАЛТ ХК" нийгмийн хариуцлагын хүрээнд TV9 телевиз, АРАГ продакшн хамтран бэлтгэдэг "МӨРӨӨДӨЛ БИЕЛДЭГ" хумууцэгийн зорилгот төсөлд хамтран ажиллаж Нийслэлийн Онцгой байдлын байгууллагад 13 дахь жилдээ ажиллаж байгаа СХД-ийн Онцгой байдлын хэлтсийн аврагч, гал сөнөөгч, ахлах ахлагч Ж.Пүрэвдэмбэрэлийн гэр бүдийн хүсэл мөрөөдлийг биелүүлдэг тус нэмэр болсондоо таатай байна.




ЦАГААГЧИН ҮХЭР ЖИЛИЙН АНХНЫ АЗТАН ШАЛГАРУУЛАХ

Байраа дахин дулаалах, сая төгрөгийн үнэ бүхий #Базальтвүүл #чулуун хөвөн дулаалгын материал авах эрхийн бичиг олгоно.



БАЗАЛТ ЧУЛУУГ ХАЙЛУУЛАН ҮЙЛВЭРЛЭСЭН ХӨВӨНГ ЗӨВХӨН ХҮНД, ХӨНГӨН АЖ ҮЙЛДВЭРТ ХЭРЭГЛЭЭД ЗОГСОХГҮЙ ХӨДӨӨ АЖ АХҮЙН ШИНЭ САЛБАР БОЛСОН ГИДРОПОНИК ТЕХНОЛОГИТ ӨРГӨН ХЭРЭГЛЭГДЭЖ БАЙНА. ЭНЭХҮҮ ТЕХНОЛОГИ НЬ ЭНГИЙН ТАРИАЛАЛТТАЙ ХАРЬЦУУЛАХАД УСЫГ 80% ХЭМНЭДЭГ БА УРГАЛТЫГ 22% ХУРДАСГАДАГ.

БАЗАЛТ ХҮЛЭМЖИНД ЧУЛУУН ХӨВӨН ДЭЭР ҮРЛЭН ПОМИДОР ШАНЦАЙНЫ УРГАМАЛ АМЖИЛТТАЙ ТАРЬСАН.



ГИДРОПОНИК



Монгол базальт ХК-ны дулаан тусгаарлагч материалын үйлдвэрийн оёмол хөнжлийн хэсэгт 2021 оны эхний хагас жилд Уулын баяжуулах Эрдэнэт үйлдвэрийн Дулааны цахилгаан станцад Ф-325-н 10 см-н зузаантай 120 метр, Ф-426-н 10 см-н зузаантай 150 метр торон гадаргуутай хөнжил хийж өгөх ажил хийгдсэн бөгөөд түүнчлэн зах зээлд нэвтрүүлж зарахаар 174 метр 5 см-н зузаантай хөвөнд тор барьж оёх ажил хийж гүйцэтгэсэн.

Ажлын үйл явцыг дараах зургаар хавсаргав.



Зураг 1

2021 оны эхний хагас жилд дулаан боловсруулах камерт хийгдсэн шинэчлэлээр дулаан боловсруулах камерийг 24 метр урт болгон 1 дизель зуух нэмж 3н дизель форсункаар ажилладаг болсон бөгөөд дизель түлшний цагийн зарцуулалт норм тооцоогоор 105 литр зарцуулахаар тооцогдож 3 дизель зуухаар ажиллах үед 105-110 литр түлш зарцуулж байв.



2021 ОНД 3-Р САРД АШИГЛАЛТАН ОРОХ ЧУЛУУН ХӨВӨН ДУЛААЛГАТАЙ ХЭСЭГЧИЛЭН УГСРАХ СЭНДВИЧ ХАВТАН СУУРИЛУУЛХААР АЖИЛЛАЖ БАЙНА. ЭНЭХҮҮ БҮТЭЭГДХҮҮНЭЭР ҮЙЛДВЭРЛЭЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗОРИУЛАЛТААР БАРИЛГАД АШИГЛАНА.



Үйлдвэр нь жилд 512.4-1244.1 мян.м базальт файбер (BFRP) арматур үйлдвэрлэх хүчин адалтай бөгөөд захиалагчийн хүссэн марк, хүссэн урттайгаар хуйлмал болон тайрмал хэлбэртэй BFRP маркын арматур үйлдвэрлэнэ.



СУРГАЛТЫН ТӨВ
SHOWROOM



Хаяг: ХУД-н Мишээл барилгын их дэлгүүрийн 2 давхарт, “Монгол Базальт” ХК сургалт сурталчилгааны төв
Утас: 7700 6768

МЭДЭЭЛЭЛ ИННОВАЦИЙН ТӨВ



Хаяг: Чингэлтэй дүүрэг, 12-р хороо, Агаар орчны бохирдлыг бууруулах “Мэдээлэл инновацийн төв”
Утас: 7777 1992

СУРГАЛТ, СУРТЧИЛГААНИЙ ЦЭГ



Хаяг: Сонгино хайрхан дүүрэг, Үйлдвэрчний гудамж-37, “Монгол Базальт” ХК сургалт сурталчилгааны төв
Утас: 9907 6692



Манай компани нь агаар орчны бохирдлыг бууруулах эрчим хүч, дулаан хэмнэлтийн сургалтыг 2017 оноос хойш үнэ төлбөргүй зохион байгуулж иргэд болон аж, ахуйн нэгжүүдийг хамруулж ирсэн. Чингэлтэй дүүрэг, Сонгино Хайрхан дүүргүүдэд шинээр сургалт сурталчиггаа, мэдээллийн төвүүдээр үйлчилж чулуун хөвөн дулаан тусгаарлагч материалын ач холбогдлыг хүн бүрт таниулахыг зорин ажиллаж байна.

Үйл ажилгааны тайлан



www.Basaltwool.mn



Сүхбаатар дүүрэг 1-р хороо
Энхтайвны өргөн чөлөө,
Фламинго цамхаг 7 давхар



7511-4444



Monbasalt@rockwool.mn



Mongolbasalt JSC